



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/90/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 260512 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Аудитор: Д.Мөнхжин Утас: 261628 Цахим хаяг: munkhjind@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн захирал : С.Тунгалаг Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН
ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б.ИЧИНХОРЛОО ТАНАА

2024.03.15 № 07/745
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ нь 7 байршилд 4.9291 га газрын гэрчилгээ шинээр гаргуулах, 2 байршлын 1.2230 га газрын хугацааг сунгуулах хүсэлтүүдийг Нийслэлийн засаг дарга бөгөөд хотын захирагчид хүргүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2023 оны А/45 дугаар тушаалаар 2023 оны 7 дугаар сард Улаанбаатар хотод болсон үер усны гамшигт өртсөн өмч хөрөнгөд хохирлын үнэлгээ хийх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах ажлын хэсгийг байгуулж, Хохирлын үнэлгээний институтээс үерийн гамшигт үзэгдлийн улмаас учирсан нийт хохирлыг 543.7 сая төгрөгөөр тогтоож, байгууллагын үйл ажиллагааг тогтворжуулах, сэргээн босгох үйл ажиллагаанд нийт 158.8 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 39 зорилтын хүрээнд 153 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,280,770,006.89	3,153,581,958.11
1.1.2	Дансны авлага	10,967,679.00	42,171,642.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	27,494,694.53	58,180,346.70
1.1.4	Бусад авлага	416,570,345.65	403,679,059.71
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	2,000,000,000.00
1.1.6	Бараа материал	1,032,198,184.34	895,638,666.44
1.1.11	<i>Эргэлтийн хөрөнгийн дүн</i>	<i>6,768,000,910.41</i>	<i>6,553,251,672.96</i>
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	21,886,609,694.09	21,964,037,616.72
1.2.2	Биет бус хөрөнгө	9,314,267,722.80	9,312,120,616.70
1.2.10	<i>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</i>	<i>31,200,877,416.89</i>	<i>31,276,158,233.42</i>
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	37,968,878,327.30	37,829,409,906.38
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	524,753,578.69	-
2.1.1.1	Дансны өглөг	29,563,259.45	-
2.1.1.3	Татварын өр	4,496,691.05	5,959,900.57
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	10,000,000.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	358,333,574.05
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	558,813,529.19	374,293,474.62
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	642,605,176.16
	Хойшлогдсон татварын өр		642,605,176.16
2.2	<i>Өр төлбөрийн нийт дүн</i>	<i>558,813,529.19</i>	<i>1,016,898,650.78</i>
2.3	Эздийн өмч	-	-
2.3.1	Өмч - төрийн	15,103,851,256.35	15,103,851,256.35
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	10,044,892,317.75	8,895,715,168.76
2.3.9	Хуримтлагдсан ашиг	12,261,321,224.01	12,812,944,830.49
2.3.10	Тайлант үеийн ашиг	-	-
2.3.11	<i>Эздийн өмчийн дүн</i>	<i>37,410,064,798.11</i>	<i>36,812,511,255.60</i>
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	37,968,878,327.30	37,829,409,906.38

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,308,470,643.73	4,135,526,490.60
2	Борлуулалтын өртөг	4,039,646,207.52	5,345,323,442.41
3	Нийт ашиг (алдагдал)	1,268,824,436.21	(1,209,796,951.81)
4	Түрээсийн орлого	-	3,064,405,439.93
5	Хүүгийн орлого	267,041,095.89	588,058,208.68
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	976,231,568.74	5,410,217.03
9	Борлуулалт, маркетингийн зардал	15,058,849.78	9,619,083.18
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,065,787,599.81	2,021,527,288.51
11	Санхүүгийн зардал	-	13,362,036.65
12	Бусад зардал	18,079,599.48	14,581,645.94
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	256,841,139.38	(2,415,611.13)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(51,458,500.04)
18	Татварын өмнөх ашиг (алдагдал)	670,012,191.15	335,112,748.38
19	Орлогын татварын зардал	129,403,762.65	34,969,439.43
20	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
21	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	540,608,428.50	300,143,308.95
22	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
22.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
22.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
22.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	540,608,428.50	300,143,308.95

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,093,439,330.06	8,136,634,580.40
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,816,429,695.21	7,758,320,260.39
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	59,520,872.70
1.1.5	Бусад мөнгөн орлого	277,009,634.85	318,793,447.31
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,668,736,753.63	7,031,097,588.69
1.2.1	Ажиллагсад олгосон мөнгө	1,675,576,023.00	2,070,703,067.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад олгосон мөнгө	476,067,804.39	584,816,584.83
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	553,376,772.17	793,682,820.28
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	1,798,260,125.28	2,331,423,832.47
1.2.5	Шатахуун, тээврийн зардалд төлсөн мөнгө	229,942,912.45	354,156,704.10
1.2.7	Татварын байгууллагад төлсөн мөнгө	639,344,057.46	589,118,916.84
1.2.8	Даатгалын байгууллагад төлсөн мөнгө	15,247,113.00	22,688,837.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	280,921,945.88	284,506,826.17
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,424,702,576.43	1,105,536,991.71
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	240,336,986.30	265,619,852.51
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	240,336,986.30	265,619,852.51
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	841,949,298.55	1,228,040,693.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	841,949,298.55	1,228,040,693.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(601,612,312.25)	(962,420,840.49)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,000,000.00	270,304,200.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	10,000,000.00	270,304,200.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(10,000,000.00)	(270,304,200.00)
4	Гадаад валютын зөрүү	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	813,090,264.18	(127,188,048.78)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,467,679,742.71	5,280,770,006.89
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,280,770,006.89	5,153,581,958.11

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	12,162,775,856.35	9,923,397,388.86	11,586,704,450.45	33,672,877,695.66
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	144,008,345.07	144,008,345.07
3	Залруулсан үлдэгдэл	12,162,775,856.35	9,923,397,388.86	11,730,712,795.52	33,816,886,040.73
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	540,608,428.50	540,608,428.50
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	2,941,075,400.00	121,494,928.88	-	3,062,570,328.88
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	(10,000,000.00)	(10,000,000.00)
9	2023 оны 01-р сарын 01 -ний үлдэгдэл	15,103,851,256.35	10,044,892,317.74	12,261,321,224.02	37,410,064,798.11
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	521,784,497.52	521,784,497.52
11	Залруулсан үлдэгдэл	15,103,851,256.35	10,044,892,317.74	12,783,105,721.54	37,931,849,295.63
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	300,143,308.95	300,143,308.95
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	(270,304,200.00)	(270,304,200.00)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(1,149,177,148.98)	-	(1,149,177,148.98)
17	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	15,103,851,256.35	8,895,715,168.76	12,812,944,830.49	36,812,511,255.60

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны төлөвлөгөө	2023 оны гүйцэтгэл	Харьцуулалт	
					Дүн	Хувь
<i>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн гол нэр төрлөөр:</i>						
1	1.1 Үйлчилгээ, ашиглалтын орлого	мян/төг	2,896,490.0	2,866,720.4	(29,769.6)	99.0
	1.2 ЭСЯ-уудын түрээсийн орлого	мян/төг	2,526,434.0	2,520,541.5	(5,892.5)	99.8
	1.3 Зоогийн үйлчилгээний орлого	мян/төг	542,460.0	538,384.9	(4,075.1)	99.2
	1.4 Автобаазын орлого	мян/төг	445,325.0	485,191.5	39,866.5	109.0
	1.5 Бусад түрээсийн орлого	мян/төг	533,948.0	543,864.0	9,916.0	101.9
	1.6 Бусад орлого	мян/төг	781,414.1	838,698.2	57,284.2	107.3
2	Нийт орлого	мян/төг	7,726,071.1	7,793,400.4	67,329.3	100.9
3	Нийт зардал	мян/төг	7,274,358.5	7,458,287.6	183,929.1	102.5
	Үүнээс: удирдлагын зардал	мян/төг	1,233,276.0	1,124,067.2	(109,208.8)	91.1
4	Татварын өмнөх ашиг	мян/төг	451,712.5	335,112.7	(116,599.8)	74.2
5	Цэвэр ашиг/алдагдал	мян/төг	406,541.3	300,143.3	(106,398.0)	73.8
6	<u>төсвийн төлбөрт нийт дүн</u>	мян/төг	1,304,421.0	1,312,135.0	7,714.0	100.6
	а/ Орлогын албан татварт	мян/төг	45,171.0	15,000.0	(30,171.0)	33.2
	б/ НӨАТатвар	мян/төг	380,345.0	376,523.3	(3,821.7)	99.0
	в/Ус ашигласны төлбөр		8,359.0	5,491.0	(2,868.0)	65.7
	г/ НДШ	мян/төг	534,254.0	584,816.6	50,562.6	109.5
	д/ Хувь хүний орлогын татвар	мян/төг	199,916.0	188,733.9	(11,182.1)	94.4
	е/ Тээврийн хэрэгслийн татвар	мян/төг	4,833.0	6,171.2	1,338.2	127.7
	ё/ Бусад татвар	мян/төг	30,568.0	34,243.9	3,675.9	112.0
	НХАТ	мян/төг	1,600.0	4,389.7	2,789.7	274.4
	Газрын төлбөр	мян/төг	28,968.0	29,854.2	886.2	103.1
	ж/ Түрээсийн орлогоос төвлөрүүлэх	мян/төг	100,975.0	101,155.1	180.1	100.2
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян/төг	270,304.2	270,304.2	-	100.0
8	Нийт ажилтны тоо	хүн	165.0	165.0	-	100.0
9	Нийт цалингийн сан	мян/төг	2,510,414.0	2,481,913.7	(28,500.3)	98.9
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян/төг	1,267.9	1,253.5	(14.4)	98.9
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян/төг	0.9	1.0	0.0	101.6
12	Хөрөнгө оруулалт	мян/төг	1,303,183.8	1,228,040.7	(75,143.1)	94.2
13	Нийт авлага	мян/төг	480,000.0	529,826.4	49,826.4	110.4
	Үүнээс:Найдваргүй авлага	мян/төг	19,600.0	8,101.6	(11,498.4)	41.3
14	Нийт өглөг	мян/төг	56,624.0	21,872.9	(34,751.1)	38.6
	Богино хугацаат өр төлбөр	мян/төг	56,624.0	21,872.9	(34,751.1)	38.6
	Урт хугацаат өр төлбөр	мян/төг	-	-	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,127.0 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 3,127.0 сая төгрөгийн 15 алдааг залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2023 оны цалин түүнтэй адилтгах орлогын албан татварын тайланд 35 ажилчны цалин хөлсийг 16.5 сая төгрөгөөр илүү, 1 ажилтны цалин хөлсийг 3.8 сая төгрөгөөр дутуу, нийт 20.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	20,324.9	-	-	1	20,324.9	1	20,324.9	-	-	-	-
2	Худалдаа хөгжлийн банканд байршуулсан 3 сараас дээш хугацаатай 2,000.0 сая төгрөгийн хадгаламжийг мөнгөн хөрөнгөөр бүртгэж санхүүгийн байдлын тайланд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн бүрэлдэхүүнд оруулж тайлагнасан байна.	1	2,000,000.0	-	-	1	2,000,000.0	1	2,000,000.0	-	-	-	-
3	Тайлант оны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд 724 ширхэг дахин үнэлэгдсэн хөрөнгөнд байгуулсан 464.0 сая төгрөгийн элэгдлийн зардлыг татвар ногдох орлогоос хасаж тооцоолсон байна.	1	463,946.2	-	-	1	463,946.2	1	463,946.2	-	-	-	-
4	Тайлант оны завсрын аудитаар илэрсэн алдааны залруулгыг алдаатай хийсний улмаас 4 ажилтанд 0.1 сая төгрөгийг байгууллагын нийгмийн	1	115.4	-	-	1	115.4	1	115.4	-	-	-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

	даатгалын шимтгэлийн зардалд тусгасан байна.												
5	Тайлант онд Миг даатгалаас төлсөн даатгалын нөхөн төлбөрийн орлого 3.9 сая төгрөгийг авто баазын зардалд бичилт хийж орлогыг дутуу тайлагнасан байна.	1	3,906.7	-	-	1	3,906.7	1	3,906.7	-	-	-	-
6	Гадаад харилцааны яаманд бараа ажил үйлчилгээ үзүүлсний орлого 93.8 сая төгрөгийн 2 удаагийн ажил гүйлгээг борлуулалтын орлого дансны кредитээс борлуулсан ажил үйлчилгээний өртөг дансанд авлага үүсгэхгүйгээр хааж бичсэн.	1	93,811.5	-	-	1	93,811.5	1	93,811.5	-	-	-	-
7	Борлуулсан барааны орлогоос суутгаж авсан банкны посс машины шимтгэл 5.6 сая төгрөгийн орлогыг дутуу бүртгэж банкны шимтгэлийн дансанд хааж бичсэн байна.	1	5,631.2	-	-	1	5,631.2	1	5,631.2	-	-	-	-
8	Шалгагдагч байгууллага нь 73.3 сая төгрөгийн шатахууныг бараа материалын дансанд орлого авахгүйгээр шууд зардлаар бүртгэсэн байна.	1	73,260.9	-	-	1	73,260.9	1	73,260.9	-	-	-	-
9	Хүүгийн орлогыг татвар суутгасан дүнгээр бүртгэснээс 57.9 сая төгрөгийн орлогыг дутуу бүртгэсэн байна.	1	57,854.1	-	-	1	57,854.1	1	57,854.1	-	-	-	-
10	Мөнгөн гүйлгээний тайланд урьдчилгаа цалингийн зөрүү 2.6 сая төгрөгийг ашиглалтын зардлаар тайлагнасан байна.	1	2,619.6	-	-	1	2,619.6	1	2,619.6	-	-	-	-
11	Өглөгийн үлдэгдэлгүй 35.9 сая төгрөгөөс 101.2 сая төгрөгийн хооронд хийгдсэн гүйлгээтэй 3 харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	-	-	-	1	-	1	-	-	-	-	-

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

12	Тайлант онд 2 ажилтны цалин хөлсийг нийгмийн даатгалын шимтгэлд тайлагнахдаа 1.4 сая төгрөгөөр илүү тайлагнасныг улмаас даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлд 0.3 сая төгрөгийг байгууллагаас төлж барагдуулсан байна.	1	334.5	-	-	1	334.5	1	334.5	-	-	-	-
13	Тайлант онд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг 43 ажилтанд 0.4 сая төгрөгөөр илүү, 68 ажилтанд 1.1 сая дутуу, нийт 1.5 сая төгрөгөөр зөрүүтэй тооцож тайлагнасан байна.	1	1,490.1	-	-	1	1,490.1	1	1,490.1	-	-	-	-
14	Нийт 29 байгууллагын 403.7 сая төгрөгийн он дамжсан авлагыг тооцоо нийлж, барагдуулаагүй байна.	1	403,713.1	-	-	1	403,713.1	1	403,713.1	-	-	-	-
15	Ашиглагч иргэн, хуулийн этгээдийн хэрэглэсэн цахилгааны төлбөр 1,313.3 сая төгрөг, усны төлбөр 383.2 сая төгрөг, дулааны төлбөр 931.6 сая төгрөг нийт 2,628.1 сая төгрөгийн зардлын дүнгээр нэхэмжлэгч байгууллагуудад өглөг үүсгэж бүртгээгүй, шууд төлсөн дүнгээр ашиглагч орлогын данснаас байгууллагаас авах авлага, борлуулсан бүтээгдэхүүний өртөг дансанд бичилт хийн бүртгэж тайлагнасан байна.	1	-	1	-	1	-	1	-	-	-	-	-
	Дүн	15	3,127,008.4	1	-	15	3,127,008.4	15	3,127,008.4	-	-	-	-

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитаар нийт 36.3 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 5.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 20.6 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 10.2 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага Тооцуулах Албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Тайлант онд 1 ажилтны цалин хөлснөөс сахилгын шийтгэл болох 0.2 сая төгрөгийг суутгаагүй байна.	1	150.1	1	150.1	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	Тайлант онд 3.7 сая төгрөгийн буцалтгүй тусламжаас хувь хүний орлогын албан татвар 0.3 сая төгрөгийг суутгаагүй олгосон байна.	1	368.0	1	368.0	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	Тайлант онд 3 ажилтанд захирлын тушаалын дагуу сахилгын шийтгэл оногдуулсан боловч үндсэн цалинг бууруулаагүй, цалингийн суутгалд мөнгөн дүнгээр суутгасан байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

4	Тайлант онд давхардсан тоогоор 52 ажилтны томилолтоор ажилласан хугацаанд 1.4 сая төгрөгийн хоол, унааны нөхөн олговрыг давхардуулан олгосон байна.	1	1,411.8	1	1,411.8	-	-	-	-	-	-	-	-
5	Албан томилолтын зардлыг анхан шатны баримттай тулган шалгахад 21 хүнд 0.9 сая төгрөгийн албан томилолтыг илүү олгосон байна.	1	933.1	1	933.1	-	-	-	-	-	-	-	-
6	Анхан шатны бүрдүүлэлт дутуу баримтаар 11 хүнд 7.7 сая төгрөгийн томилолтыг олгосон байна.	1	7,655.6	-	-	1	7,655.6	-	-	-	-	-	-
7	Тайлант жилд шатахуун зарцуулалтын тайланг давтан тооцоолоход нийт 4,055.05л 13.0 сая төгрөгийн шатахууныг нормоос илүү тооцож олгосон байна.	1	12,979.7	-	-	1	12,979.7	-	-	-	-	-	-
8	Шалгагдагч байгууллага нь Төрийн өмчийн байгууламжийг түрээслэх 59 гэрээний 13.3 сая төгрөгийн орлогоос төсөвт төвлөрүүлэх 20% болох 2.7 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна.	1	2,656.7	1	2,656.7	-	-	-	-	-	-	-	-

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

9	Худалдан авсан хөрөнгө, материалын дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн цахим баримтын дүнгээс 11 иргэн байгууллагын дүнг 10.2 сая төгрөгөөр дутуу дүнгээр бүртгэгдсэн байна.	1	10,171.7	-	-	-	-	1	10,171.7	-	-	-	-
	Дүн	9	36,326.7	5	5,519.7	2	20,635.3	2	10,171.7	-	-	-	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 174.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0.7 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 173.8 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/					
		Нийт зөрчил		Үүнээс			
		Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
1	Тайлант оны шилэн дансны цахим хуудсыг шалгахад нийт 158 мэдээлэл байршуулахаас хугацаандаа оруулсан 98, оруулах мэдээлэл байхгүй 59, хүлээгдэж байгаа 1 мэдээлэл байна. Шилэн дансанд мэдээлсэн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг Мөнгөн гүйлгээний журналын орлого, зарлагын дүнтэй тулгахад 5 удаагийн 45.4 сая төгрөгийн орлогын гүйлгээг хугацаа хоцроосон, 2 удаагийн 128.4 сая төгрөгийн зарлагын гүйлгээг хугацаа хоцроосон байна.	1	173,855.7	-	-	1	173,855.7
	Дүн	1	173,855.7	-	-	1	173,855.7
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
1	Шалгагдагч байгууллага дээр бүртгэлтэй нийт 51 машинаас 11 машины улсын дугаар цэнхэр, 40 машины улсын дугаар цагаан өнгөтэй байна.	1	-	-	-	1	-
2	Чин Ван Ханддоржийн өргөөний гэрийн эсгийн давхаргыг шинэчлэх тендерт 37.9 сая төгрөгөөр санал ирүүлсэн байгууллагатай 38.7 сая төгрөгөөр буюу 0.8 сая төгрөгөөр илүү дүнгээр гэрээ байгуулсан байна.	1	760.0	1	760.0	-	-
	Дүн	2	760.0	1	760.0	1	-
	Нийт дүн	3	174,615.7	1	760.0	2	173,855.7